



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 5/07

Бор-өндөр сум

**Ш.Итгэл-Эрдэнийг үйлчлэгчээр  
түр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 тоот тогтоолын 6 дугаар хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 тоот тогтоолын 11 дүгээр хавсралт, 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоолын хавсралт, 2020 оны “Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай” А/69 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шархүүгийн Итгэл-Эрдэнийг 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн үйлчлэгчээр 3 сарын хугацаатай түр томилон ажиллуулсугай.

2. Ш.Итгэл-Эрдэнийг 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн ТҮ1 шатлалаар тогтоон үндсэн цалинг 954,000 (есөнзуун тавин дөрвөн мянга), Орон нутагт ажилласны нэмэгдэл цалингийн 40% 381.600 (гурванзуун наян нэгэн мянга зургаан зуу), хоолны мөнгө өдрийн 10.000 (арван мянга) төгрөгөөр тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-т зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллахыг Ш.Итгэлт-Эрдэнэд үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАТБААТАР

